

## **ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН 2019 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТЭД ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ ТАЙЛАН**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсэгт заасны дагуу Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам” /цаашид “журам” гэх/-ын 3 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийг үндэслэн Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн төлөвлөгөө, тендер шалгаруулалтын явц, цахим тендер шалгаруулалтын урилга, үр дүн болон гомдлын судалгаанд үндэслэн үнэлгээ өгсөн болно.


Худалдан авах ажиллагааны 2019 оны тайланг 13 яам, нийслэл, 21 аймаг болон бусад 19 байгууллага бүхий нийт 54 төсвийн ерөнхийлөн захирагч ирүүлэхээс 47 төсвийн ерөнхийлөн захирагч ирүүлсэн байна. Үүнээс Төрийн албаны зөвлөлийн дарга, Хүний эрхийн үндэсний комиссын дарга, Монгол банкны ерөнхийлөгч тайлан ирүүлээгүй, Улсын Их Хурлын Тамгын газраас төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагаа зохион байгуулсан, Ерөнхийлөгчийн тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах үндэсний комиссын даргын багц тухайн онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй тухай албан бичиг ирүүлсэн.

Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр 2019 онд нийт 3,103 /гурван их наяд нэг зуун гурав/ тэрбум төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөж, нийт 2,643 /хоёр их наяд зургаан зуун дөчин гурав/ тэрбум төгрөгийн өртөг бүхий гэрээ байгуулж ажилласан байна. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх шинээр эхлэх нийт 908 төсөл, арга хэмжээнд 1,037.7 тэрбум төгрөг батлагдаж 942.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож гүйцэтгэл 90.7 хувьтай байна.

### **Төсвийн ерөнхийлөн захирагч нарын үнэлгээний талаар:**


Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 оны худалдан авах ажиллагаанд өгсөн үнэлгээний дүнгээр Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Батлан хамгаалахын сайд, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Орхон, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн Засаг дарга, Авлигатай тэмцэх газрын дарга, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч, Шадар сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга нар 80-89 хувь буюу “Сайн”, Барилга, хот байгуулалтын сайд, Зам тээврийн хөгжлийн сайд, Гадаад харилцааны сайд, Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайд, Эрчим хүчний сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай аймгийн Засаг дарга болон Нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын Ерөнхий сайдын багц, Улсын Ерөнхий прокурор, Үндсэн хуулийн цэц, Үндэсний ерөнхий аудитор нар 60-79 хувь буюу “Хангалттай”, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Булган аймгийн Засаг дарга, Үндэсний статистикийн газрын дарга нар 40-59 хувь буюу “Хангалтгүй” үнэлгээ тус тус авсан байна.

**Худалдан авах ажиллагааны үнэлгээ  
/Төсвийн ерөнхийлөн захирагчаар/**




Үүнээс тайлан ирүүлээгүй - 4, хөрөнгө оруулалт батлагдаагүй - 1, үнэлэх боломжгүй - 1, УИХ-ийн тамгын газар 2019 онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг хуулийн 3.4 дэх хэсгийн дагуу авсан байх тул нийт 7 төсвийн ерөнхийлөн захирагчийг үнэлгээнд хамруулаагүй болно. **Улсын хэмжээнд** 2019 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилт нийт **73** хувь буюу “Хангалттай” гэж үнэлэгдсэн.

**Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хийсэн  
үнэлгээний нэгдсэн дүн /2006-2019 он/**



Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017-2019 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээг сайд, Засаг дарга, бусад буюу Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг, шүүхийн байгууллагууд тус бүрээр танилцуулбал:

**Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ  
/2017-2019 он/**



Дээрх үзүүлэлтээс үзэхэд 2019 онд яамдын худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн дундаж нь 72 хувь, бусад төсвийн ерөнхийлөн захирагчид 68 хувь, аймгууд 77 хувь буюу “хангалттай” тус тус гэж үнэлэгдэж байна. Төрийн худалдан

авах ажиллагааны цахим системийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор тус яамнаас журамд өөрчлөлт оруулан төлөвлөлт, тайлагналтыг тухай бүр хянаж ажиллаж байгаа нь худалдан авах ажиллагааны гүйцэтгэл сайжирч байна.

### **Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн шинэчлэл:**

Монгол Улсын Их Хурал Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр баталсантай холбогдуулан эрх зүйн хүрээнд 1 дүрэм 6 журмыг шинээр болон шинэчлэн баталлаа.

Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоолоор “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм” болон “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”-ыг тус тус баталлаа. Энэхүү дүрэм, журамд үндэслэн худалдан авах ажиллагаанд оролцохдоо илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлсэн, гэрээний үүргээ биелүүлээгүй, авлигын гэмт хэрэгт холбогдсон аж ахуйн нэгжийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах зорилготой юм.

Түүнчлэн Сангийн сайдын тушаалаар “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”, “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”, “Урьдчилсан худалдан авах ажиллагааны журам”, “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам”, “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ыг тус тус батлаад байна.


Худалдан авах ажиллагааны эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд 2020 онд Сангийн яамнаас жишиг баримт бичиг, тендерийн үнэлгээний заавар, дотоодын давуу эрх тооцох аргачлал зэрэг бодлогын баримт бичгийг шинэчлэн батална.

### **Худалдан авах ажиллагааны холбогдох журмыг баримталсан байдал:**

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай 2019 оны нэгдсэн тайлангаас үзэхэд Монгол Улсын хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр нийт **2,643.0** тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн ба үүнээс **87.1** хувь буюу **2,300.8** тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, **5.2** хувь буюу **138.7** тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар, **0.2** хувь буюу **5.1** тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аргаар, **6.7** хувь буюу **177.5** тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг гэрээ шууд байгуулах аргаар, **0.7** хувь буюу **19.3** тэрбум төгрөгийг шууд худалдан авалтаар, **1.6** тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар тус тус хэрэгжүүлсэн байна.

Тайлант хугацаанд нийт 13,837 тендер шалгаруулалт зохион байгуулж үүнээс 3,477 нээлттэй тендер шалгаруулалт, 4,696 харьцуулалт, 586 гэрээ шууд байгуулах, 26 хязгаарлагдмал тендер шалгаруулалт, 4,501 шууд худалдан авалт, 127 олон нийтийн оролцоотой, 424 зөвлөх үйлчилгээний журмаар тус тус тендер шалгаруулалт зохион байгуулсан байна.

**Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 оны худалдан авах ажиллагааны дүн, журмын ангиллаар /тэрбум төгрөг/**




**Худалдан авах ажиллагааны цахим системийг ашигласан байдал:**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэгт захиалагч тендер шалгаруулалт бүрийн урилга, үр дүнг цахим сүлжээнд тухай бүр зарлаж байхаар хуульчилсан.

Монгол Улсын Засгийн газраас төрийн болон орон нутгийн төсвийг үр ашигтай захиран зарцуулах, худалдан авах ажиллагааг хурдан шуурхай, олон нийтэд хүртээмжтэй, ил тод, нээлттэй зохион байгуулах, түүнд олон нийтийн хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ийг боловсруулан 2017 оноос бүх шатны төрийн байгууллагууд худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа ашиглаж байна.

**Худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт /2017-2019 он/**



Тайлант хугацаанд нийт тендер шалгаруулалтын 98 хувийг цахим системээр зохион байгуулсан байна.

Цахим системд 2019 онд 2,042 захиалагч байгууллагын 27,004 худалдан авах ажиллагааны төлөвлөгөө нийтэлсэн. Үүнээс давхардсан тоогоор 17,684 цахим тендер шалгаруулалтын урилга цахим системээр зарлажээ.

Цахим системд 9,825 аж ахуйн нэгж бүртгүүлэн цахим хэлбэрээр тендер шалгаруулалтад оролцсон бөгөөд тайлант хугацаанд 837 захиалагч нийт 15,830 тендер шалгаруулалтын үр дүнг олон нийтэд мэдээлэн ажиллалаа.

Төрийн өмчит үйлдвэр, аж ахуйн тооцоотой газар, хуулийн этгээдийн 2019 онд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тайланг төсвийн ерөнхийлөн захирагч нар нэгтгэн Сангийн яаманд ирүүлэхгүй байгаа нь дээрх тоо мэдээ Худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлсэн мэдээнээс зөрүүтэй тайлагнах гол шалтгаан болж байна.

Харин төсвийн ерөнхийлөн захирагч нарын Сангийн яаманд ирүүлсэн тайлангаас авч үзэхэд яамд нийт 2,779 тендер цахим зарлахаас 2,319 буюу 83 хувь, орон нутагт 5,672 тендерээс 5,111 буюу 90 хувь, бусад төсвийн ерөнхийлөн захирагчид 172 тендерээс 131 буюу 76 хувийг цахимаар тус тус зарласан байна.

### Худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт /төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр/



Цахим системийн үйл ажиллагааг сайжруулах, улсын хэмжээний тоон мэдээг нэг эх үүсвэрээс авах зорилгоор худалдан авах ажиллагааны явцын болон жилийн эцсийн тайланг системд үндэслэн нэгтгэж байна. Цахим системд захиалагч байгууллагууд гэрээний талаарх мэдээллийг оруулах бүрэн боломжтой ба 2019 онд 4,321 гэрээний мэдээлэл бүртгэгдээд байна.

Цаашид худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж төрийн байгууллага болон тендер оролцогч нарын хооронд байгуулсан гэрээний хуулбарыг цахим системд нийтэлж байх нь тухайн тендер оролцогчийн чадавхыг үнэлэхэд дөхөм болгох ач холбогдолтой юм.


Түүнчлэн төсвийн хөрөнгийн худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийн талаарх мэдээлэл олон нийтэд ил болж, иргэд, хөндлөнгийн байгууллагаас тавих хяналт сайжирна.

### Тендер оролцогч нараас гаргасан гомдлыг шийдвэрлэсэн байдал:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 54, 55, 56 дугаар зүйлд худалдан авах ажиллагааг зохион байгуулах явцад тендер оролцогчдын гомдол гаргахдаа аль шатанд ямар байгууллагад хандахыг тодорхой зааж өгсөн байдаг.

Тендер шалгаруулалттай холбоотой 2019 онд нийт 1,352 гомдол холбогдох байгууллагуудад гарсан байх бөгөөд үүнээс 219 гомдол буюу 16 хувь нь тендерийн нээлт хийхээс өмнөх шатанд, 1,060 буюу 78 хувь нь захиалагчийн шийдвэрт, 74 буюу 6 хувь нь гэрээнд гарын үсэг зурагдсаны дараа эсвэл Сангийн яамны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр шүүхэд тус тус хандсан байна.

#### Гомдол шийдвэрлэлт




Хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр захиалагчийн шийдвэрт буюу Сангийн яаманд тендер оролцогч тендерийн баталгаагаар барьцаалан үндэслэл бүхий гомдол гаргах шинэ зохицуулалт 2019 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон. Хуулийн үйлчлэл эхэлснээс хойш зарлагдсан тендер шалгаруулалтад гаргасан үндэслэлгүй гомдлын хэмжээ 2019 оны сүүлийн хагас жилд 92 буюу 16.2 хувь болж буурсан. Төрийн сангийн 100900000753 тоот “Тендерийн баталгааны орлого” дансанд 81,458,648 төгрөг бүхий тендерийн баталгааг улсын орлого болгон төвлөрүүлсэн байна.

Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 5 хоногийн дотор тендер оролцогч нараас ирүүлсэн гомдлыг хүлээн авч 14 хоногт хянан хариу өгдөг.

Сангийн яам тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийх 482 шийдвэр, үүнээс тендер шалгаруулалтыг хүчингүй болгох 90 шийдвэрийг захиалагч байгууллагад хүргүүлж, захиалагч буруу шийдвэр гаргасан байсныг тендер оролцогчдын хяналтаар дамжуулан зохих шатанд нь залруулсан байна.

#### Гомдлын шийдвэрлэлт /2014-2019 он/



Сангийн яам давхардаагүй тоогоор 822 тендер шалгаруулалтын үнэлгээтэй холбогдуулан 602 иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн 1,060 гомдлыг хүлээн авч,

холбогдох материалд үндэслэн хянан үзэж, хариу хүргүүлсэн байна. Үүнээс 376 гомдол буюу 32 хувь нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн байна.

Дээрх зургаас үзэхэд гэрээ байгуулахын өмнөх шатанд захиалагчийн шийдвэрт тендерт оролцогчдоос гаргасан гомдлын тоо нэмэгдсэн боловч захиалагчийн хуульд нийцээгүй шийдвэрийн тоо буурахгүй байна. Түүнчлэн тендерт оролцогчоос захиалагчийн шийдвэрт гаргасан гомдол, маргааны ихэнх буюу 54 хувь нь үндэслэлтэй байна.

Гомдол шийдвэрлэлтийн бусад төрөлд Сангийн яам гомдлыг хүлээн авах боломжгүй, гомдол гаргах хугацаанд тус яаманд хандаагүй, захиалагч байгууллага гэрээ байгуулсан, эсхүл гомдлоо эргүүлэн татсан шийдвэрийг багтаасан байна.

Гомдлын судалгаанаас авч үзвэл Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагуудаас зохион байгуулсан тендер шалгаруулалтад холбогдуулан нийт 175 гомдол ирүүлснээс 109 шийдвэр, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон төрийн өмчит үйлдвэрийн газартай холбогдуулан 174 гомдол ирүүлснээс 95 шийдвэр, Эрүүл мэндийн яам, харьяа байгууллагатай холбогдуулан 102 гомдол ирүүлснээс 56 шийдвэр, Эрчим хүчний яам, харьяа байгууллагатай холбогдуулан 92 гомдол ирүүлснээс 54 шийдвэр, Өмнөговь аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудтай холбогдуулан 40 гомдол ирүүлснээс 25 шийдвэрийг хуульд нийцүүлэн үнэлгээг дахин хийх, тендер шалгаруулалтыг дахин зохион байгуулах шийдвэрийг Сангийн яамнаас хүргүүлэн ажилласан.

Энэ нь үнэлгээний хорооны гишүүд тендер шалгаруулалтын үнэлгээг хийхдээ зохих хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаагүй, нөгөө талаас захиалагч үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт хуульд нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байгаатай холбоотой гэж дүгнэж байна.

Нөгөө талаас захиалагч тендер шалгаруулалтын эцсийн үр дүнг оролцогч нарт нэгэн ижил мэдээлэхгүй байх, Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар баталсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”-д заасны дагуу ил болгож ажиллахгүй байгаа нь гомдол гаргах нөхцөлийг бий болгож байна.

Цаашид захиалагч хуулийн 46 дугаар зүйлд заасан үүргээ хангалттай хэмжээнд хэрэгжүүлж ажиллах шаардлагатай юм.

### **Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийн талаар:**

Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоолоор “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм” болон “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”-ыг баталж хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4, 14.1.6, 14.1.7 дахь заалтад заасан нөхцөл үүссэн эсэхийг улсын байцаагчаар дамжуулан хяналт шалгалт хийх ажлыг сэргээгээд байна.

Худалдан авах ажиллагааны ерөнхий байцаагчийн удирдамжийн дагуу захиалагч байгууллага, аж ахуйн нэгжээс ирсэн нотлох баримт дээр үндэслэн 2019 онд 19 аж ахуйн нэгжийг тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулаад байна.

Нийт 11 аж ахуйн нэгж буюу “Гесак” ХХК, “Баянбалбар” ХХК, “Футурвижн” ХХК, “Ай Си Би Си” ХХК, “Төгс цас” ХХК, “Бумбат хоолой” ХХК, “Интерном” ХХК, “Монгол алтайн барагшун” ХХК, “Эверест ланд групп” ХХК, “Миланд агро” ХХК, “Аминхүү констракшн” ХХК, “Тэрхийн ундраа” ХХК илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлснийг худалдан авах ажиллагааны улсын байцаагч тогтоосон байна.

Харин гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаандаа алдаа гаргасан “Хангайн хятруун” ХХК, “Баян могод” ХХК, “Жиди” ХХК, “Меговатт” ХХК, “Ханлиг илч” ХХК, “Гэрэл төсөл” ХХК, “Монгол дайвин” ХХК-уудыг тендерт оролцох эрхээ хязгаарласан этгээдийн бүртгэлд хамруулаад байна.

Дээрх аж ахуйн нэгжүүдийн тендерт оролцох эрхийг 3 жилээр хассан бөгөөд жагсаалтыг Сангийн яам болон Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд мэдээлэн ажиллаж байна.

### **Худалдан авах ажиллагааны сургалтын талаар:**

Хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт заасны дагуу үнэлгээний хорооны бүх гишүүд худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулж байна. Дэлхийн банкны “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд 2019 онд бүх сумдын 2,850 иргэдийг худалдан авах ажиллагааны сургалтад хамрууллаа. Түүнчлэн 2019 онд худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А-3 сургалтын шалгалтад 8,752 суралцагч бүртгүүлж, 5,650 суралцагч шалгалтад тэнцсэн байна.

Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны гэрчилгээг цаасаар олгохыг зогсоож зөвхөн цахим систем [www.tender.gov.mn/mn/exam/certificate/](http://www.tender.gov.mn/mn/exam/certificate/)-ээр дамжуулан шалгалтад тэнцсэн тухайн өдрөө гэрчилгээг гардан авах боломжтой боллоо. Гэрчилгээг системээр дамжуулан олгох нь Төрийн худалдан авах ажиллагааны газар болон гэрчилгээ авахаар ирдэг иргэдийн зардал, ачааллыг бууруулах юм.

Түүнчлэн хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэгт үнэлгээний хороонд орж ажиллах иргэн, төрийн бус байгууллагын төлөөллийг тэднийг төрийн зардлаар мэргэшүүлж сургах ажлын хүрээнд Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр Цахим сургалтын систем [www.surgalt.tender.gov.mn/](http://www.surgalt.tender.gov.mn/)-ийг ашиглалтад орууллаа. Сангийн сайдын 2019 оны 37 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам”-д гэрчилгээний хүчинтэй байх хугацаа дууссан ажилтнууд давтан танхимын сургалтад хамрагдалгүйгээр хугацааг сунгах боломжийг олгоод байна.

### **Дотоодын үйлдвэрээс бараа худалдан авсан байдал:**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10<sup>1</sup> дугаар зүйл болон Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолын 2-т заасан дотоодын үйлдвэрээс бараа худалдан авсан тайланг захиалагч байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн гаргалаа. Нийт 54 төсвийн ерөнхийлөн захирагч тус тайланг ирүүлэхээс 33 төсвийн ерөнхийлөн захирагч ирүүлжээ.


Дотоодын үйлдвэрээс бараа худалдан авсан талаар худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээний нэг шалгуур үзүүлэлт болгож оруулсан нь



үндэсний үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд эерэг нөлөө үзүүлж байна.

Ирүүлсэн тайлангаас үзэхэд 2019 онд дотоодод үйлдвэрлэсэн 15 нэр, төрлийн бараанаас 151.9 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Дотоодын үйлдвэрээс бараа худалдан авсан тайлан  
/нэр төрөл бүрээр/



Дотоодод үйлдвэрлэсэн барааны худалдан авалт 2018 онд 92.5 тэрбум төгрөг байсан бол 2019 онд 151.9 тэрбум төгрөг болж өссөн байна.

### Зөрчил, дутагдал:


Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд дараах нийтлэг зөрчил, дутагдлууд илэрсэн. Үүнд:

1. Цахим системд 2019 онд 17,817 тендер шалгаруулалтын урилгыг нийтэлснээс 15,830 тендер шалгаруулалтын үр дүн нийтэлсэн ба тендер шалгаруулалтын үр дүнг олон нийтэд нийтлэхгүй байх, хугацаа хоцроох буюу жилийн төгсгөлд мэдээлж байгаа нь хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн хэрэгжилт хангалтгүй;
2. Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт заасны дагуу хүчинтэй байх хугацаанд, хуульд заасан шаардлагын дагуу шалгарсан оролцогчоос ирүүлсэн гүйцэтгэлийн баталгааг үндэслэн гэрээ байгуулдаггүй;
3. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний гүйцэтгэлийн явцад гарсан аливаа зөрчлийг арилгаж, гэрээнд заасан хугацаанд үүргийн гүйцэтгэлийг хангаж, гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу нотлох баримтын хамт тухай бүр ирүүлдэггүй;
4. Сангийн яаманд ирсэн гомдлын дийлэнх буюу 53 хувь нь хууль зөрчсөн шийдвэр гаргасан гэсэн хариу гарч байгаагаас дүгнэхэд үнэлгээний хороо тендер шалгаруулалтын үнэлгээг хийхдээ хууль, журмыг зөрчсөн, үндэслэлгүй шийдвэр гаргах, түүнд захиалагчийн зүгээс хяналт тавихгүй байгаа нь захиалагч хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2 дахь заалтын биелэлт хангалтгүй;
5. Улирлын чанартай төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнд заасан хугацаандаа зохион байгуулахгүй байгаа нийтлэг зөрчил нь хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.8 дахь заалттай нийцэхгүй байна.

\*\*\*\*\*

## Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны гүйцэтгэл /2006-2019/

Нийт худалдан авалт  
/тендер шалгаруулалтын журам, арга/



Нийт худалдан авалт  
/төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр, тэрбум төгрөг/



**Хавсралт 1. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хийсэн үнэлгээний нэгдсэн дүн**

| №            | Төсвийн ерөнхийлөн захирагч                           | 2015 оны<br>үнэлгээ<br>/хувиар/ | 2016 оны<br>үнэлгээ<br>/хувиар/ | 2017 оны<br>үнэлгээ<br>/хувиар/ | 2018 оны<br>үнэлгээ<br>/хувиар/ | 2019 оны<br>үнэлгээ<br>/хувиар/ |
|--------------|---|---------------------------------|---------------------------------|---------------------------------|---------------------------------|---------------------------------|
| <b>Яамд</b>  |   |                                 |                                 |                                 |                                 |                                 |
| 1.           | Байгаль орчин, аялал жуулчлалын сайд                  | 49                              | 35                              | 72.5                            | 73.3                            | 84                              |
| 2.           | Барилга, хот байгуулалтын сайд                        | 37                              | 23                              | 59.6                            | 48.5                            | 79                              |
| 3.           | Зам тээврийн хөгжлийн сайд                            | 36.5                            | 33                              | 92                              | 81.6                            | 67                              |
| 4.           | Батлан хамгаалахын сайд                               | 35                              | 25                              | 60                              | 82.3                            | 80                              |
| 5.           | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд          | 46                              | 25                              | 60                              | 52.2                            | 43                              |
| 6.           | Гадаад харилцааны сайд                                | 35                              | 61,3                            | 58.1                            | 63.7                            | 68                              |
| 7.           | Сангийн сайд  | 62                              | 50                              | 73.8                            | 75.5                            | 70                              |
| 8.           | Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд            | 40                              | 40                              | 72.5                            | 67.0                            | 84                              |
| 9.           | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд                    | 62                              | 42                              | 69.1                            | 58.9                            | 60                              |
| 10.          | Хууль зүй, дотоод хэргийн сайд                        | 62                              | 51.5                            | 84.3                            | 86.0                            | 81                              |
| 11.          | Эрүүл мэндийн сайд                                    | 60                              | 37                              | 68.8                            | 71.6                            | 77                              |
| 12.          | Эрчим хүчний сайд                                     | 60                              | 46                              | 68.9                            | 58.8                            | 71                              |
| 13.          | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд                      | 60                              | 66.9                            | 84.8                            | 73.3                            | 71                              |
|              | <b>Дунджаар</b>                                       | <b>48</b>                       | <b>42.6</b>                     | <b>71.1</b>                     | <b>68.7</b>                     | <b>72</b>                       |
| <b>Аймаг</b> |   |                                 |                                 |                                 |                                 |                                 |
| 14.          | Архангай аймгийн Засаг дарга                          | 80                              | 83.5                            | 72.5                            | 84.0                            | 67                              |
| 15.          | Баян-Өлгий аймгийн Засаг дарга                        | 48                              | 51.4                            | 76.3                            | 72.9                            | 68                              |
| 16.          | Баянхонгор аймгийн Засаг дарга                        | 69                              | 68.0                            | 71.3                            | 80.5                            | 79                              |
| 17.          | Булган аймгийн Засаг дарга                            | 62                              | 59.0                            | 66.3                            | 70.0                            | 53                              |
| 18.          | Говь-Алтай аймгийн Засаг дарга                        | 0                               | 60.0                            | 94.9                            | 84.4                            | 82                              |
| 19.          | Говьсүмбэр аймгийн Засаг дарга                        | 70                              | 61.6                            | 88.8                            | 83.3                            | 80                              |
| 20.          | Дархан-Уул аймгийн Засаг дарга                        | 65                              | 61.9                            | 84.4                            | 89.4                            | 84                              |
| 21.          | Дорноговь аймгийн Засаг дарга                         | 80                              | 65.5                            | 89.4                            | 86.7                            | 84                              |
| 22.          | Дорнод аймгийн Засаг дарга                            | 52                              | 66.5                            | 84.5                            | 85.0                            | 67                              |
| 23.          | Дундговь аймгийн Засаг дарга                          | 55                              | 61.0                            | 85.0                            | 82.2                            | 78                              |
| 24.          | Завхан аймгийн Засаг дарга                            | 46                              | 62.0                            | 76.3                            | 74.4                            | 79                              |
| 25.          | Нийслэлийн Засаг дарга                                | 60.5                            | 12.0                            | 71.3                            | 74.3                            | 62                              |
| 26.          | Орхон аймгийн Засаг дарга                             | 93                              | 90                              | 90.3                            | 92.2                            | 84                              |
| 27.          | Өвөрхангай аймгийн Засаг дарга                        | 58                              | 61                              | 73.1                            | 77.5                            | 74                              |
| 28.          | Өмнөговь аймгийн Засаг дарга                          | 48                              | 48                              | 86.3                            | 73.3                            | 80                              |
| 29.          | Сүхбаатар аймгийн Засаг дарга                         | 60                              | 57.5                            | 80.0                            | 85.1                            | 86                              |
| 30.          | Сэлэнгэ аймгийн Засаг дарга                           | 65.5                            | 76                              | 81.3                            | 81.0                            | 81                              |
| 31.          | Төв аймгийн Засаг дарга                               | 60.5                            | 57                              | 67.5                            | 88.0                            | 88                              |
| 32.          | Увс аймгийн Засаг дарга                               | 73                              | 71                              | 81.4                            | 80.6                            | 80                              |
| 33.          | Ховд аймгийн Засаг дарга                              | 60                              | 58.5                            | 85.0                            | 78.9                            | 87                              |
| 34.          | Хөвсгөл аймгийн Засаг дарга                           | 71.5                            | 84.5                            | 96.9                            | 87.0                            | 84                              |
| 35.          | Хэнтий аймгийн Засаг дарга                            | 69                              | 66                              | 92.3                            | 84.4                            | 86                              |
|              | <b>Дунджаар</b>                                       | <b>63.6</b>                     | <b>62.8</b>                     | <b>81.6</b>                     | <b>84.5</b>                     | <b>78</b>                       |
| <b>Бусад</b> |   |                                 |                                 |                                 |                                 |                                 |
| 36.          | Авлигатай тэмцэх газрын дарга                         | 53                              | **                              | **                              | 81.0                            | 80                              |
| 37.          | Ерөнхийлөгчийн тамгын газар                           | **                              | 0                               | 0                               | **                              | **                              |
| 38.          | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга              | **                              | 27                              | 77.1                            | 82.7                            | 78                              |
| 39.          | Монгол Улсын Ерөнхий сайдын багц                      | **                              | 27                              | 75.0                            | 83.8                            | 70                              |
| 40.          | Монгол Улсын Их Хурлын дарга                          | **                              | 38                              | 60.0                            | **                              | **                              |
| 41.          | Санхүүгийн зохицуулах хорооны дарга                   | **                              | 0                               | 19.2                            | 80.0                            | 87                              |
| 42.          | Сонгуулийн ерөнхий хорооны дарга                      | **                              | **                              | 60.8                            | 54.2                            | 80                              |
| 43.          | Төрийн албаны зөвлөлийн дарга                         | **                              | **                              | 0                               |                                 | **                              |
| 44.          | Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс | **                              | **                              | **                              | **                              | **                              |

|                         |                                      |             |             |             |             |           |
|-------------------------|--------------------------------------|-------------|-------------|-------------|-------------|-----------|
| 45.                     | Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч     | **          | 80          | 73.8        | 80.0        | 83        |
| 46.                     | Улсын Ерөнхий прокурор               | 74          | 80          | 41.7        | 63.5        | 74        |
| 47.                     | Үндсэн хуулийн цэц                   | **          | 0           | **          | 71.6        | 60        |
| 48.                     | Үндэсний аюулгүй байдлын зөвлөл      | **          | **          | 0           | **          | **        |
| 49.                     | Үндэсний ерөнхий аудитор             | 53.5        | 46          | 0           | 60.0        | 60        |
| 50.                     | Үндэсний статистикийн газрын дарга   | 81          | **          | 61.4        | 71.6        | 49        |
| 51.                     | Хүний эрхийн Үндэсний комиссын дарга | **          | **          | **          | **          | **        |
| 52.                     | Шадар сайд                           | 50.5        | 38          | 75.0        | 74.4        | 80        |
| 53.                     | Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга      | 61          | 64          | 88.1        | 73.9        | 84        |
| 54.                     | Монгол банк                          | 0           | 0           | 0           | 0           | 0         |
| <b>Дунджаар</b>         |                                      | <b>61.6</b> | <b>54.1</b> | <b>63.2</b> | <b>72.0</b> | <b>68</b> |
| <b>Нийт дундаж хувь</b> |                                      | <b>58</b>   | <b>56.0</b> | <b>72.0</b> | <b>75.0</b> | <b>73</b> |

\*\* - Худалдан авалт байхгүй.

0 -Тайлан ирүүлээгүй.

--o0o--